



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/125

Улаанбаатар хот


Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 3 дугаар хэсгийн 3.1.3, 3.1.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн зарим гудамж, цэцэрлэгт гоёл чимэглэлийн мод, сөөгийг тарих болон ногоон байгууламжийн хөрсийг ариутгах, ургамлын өвчин, хортон шавьжтай тэмцэх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр, хотын зарим гудамж, цэцэрлэгт гоёл чимэглэлийн мод сөөг тарих, арчлах ажлын байршил, тоо хэмжээ, зардлын задаргааг 2 дугаар, ногоон байгууламжийн хөрсийг ариутгах ажил хийгдэх гудамж, цэцэрлэг, зарцуулах хөрөнгийг 3 дугаар, өвчин, хортон шавьжтай тэмцэх ажил хийгдэх гудамж, цэцэрлэг, зарцуулах хөрөнгийг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Дээрх ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 11 сарын 15 өдрийн
А.Н.Б. тушаалын 14420/19 хавсралт



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний хорооны дарга	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Сүхбат	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ногоон байгууламжийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Д.Нааяа	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Т.Мөнхнасан	Улаанбаатар хот. Сүхбаатар дүүргийн 3-р хороо. 24-р байр. 39 тоотод оршин суугч иргэн. /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Л.Баатарцогт	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ногоон байгууламжийн арчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2019 оны 05 сарын 02 өдрийн
 А/125 тушаалын 1 дугаар хавсралт




ГОЁЛ ЧИМЭГЛЭЛИЙН МОД, СӨӨГ ТАРИХ, АРЧЛАХ АЖЛЫН
 БАЙРШИЛ, ТОО ХЭМЖЭЭ, ЗАРДЛЫН ЗАДАРГАА

Гудамж цэцэрлэг, хийгдэх ажлын нэр, Ойн төглүүдийн байршил	Ажлын тоо хэмжээ	Зардал /сая. төг/
<i>Нэг. Наадамчдын зам /Яармаг, Нисэх/ дагууд мод сөөг тарих, арчлах ажил</i>		
1.1 Фермерийн автобусны буудлаас Арцат хотхон хүртэл №420-406 дугаартай нарс модны хооронд Голт бор, Хайлаас тарих, арчлах	465 у.м	26.0
1.2 Арцат хотхоны хойд талаас British school-ийн зүүн талын эко хавтан хүртэл №405-326 дугаартай нарс модны хооронд	423 у.м	24.8
1.3 British school-ийн автобусны буудлаас Гарден ситигийн авто машины зогсоол хүртэл №325-205 нарс модны хооронд	450 у.м	25.0
1.4 Гарден ситигийн авто машины зогсоолоос баруун тийш №-204-98 дугаартай нарс модны хооронд	462 у.м	25.5
1.5 № 97-1 дугаартай нарс модны хооронд	440 у.м	25.3
1.6 BMW-ийн хойноос KGTegbe № 620-518 дугаартай мод	458 у.м	24.0
1.7 KGTegbe-ийн замын урд талын туслах замаас баруун тийш Яармагийн цагдаагийн хэлтэс хүртэл № 517-416 дугаартай мод	468 у.м	23.8
1.8 Цагдаагийн хэлтсээс Оргил худалдааны төв хүртэл №415-316	480 у.м	24.2
1.9 Оргил худалдааны төвөөс 118-р сургууль №315-215 мод	480 у.м	24.8
1.10 118-р сургуулийн автобусны буудлын баруун талаас Нисэх рүү өгсөх замын урд талын автобусны буудал хүртэл №214-109	487 у.м	24.9

1.11 Нисэх рүү өгсөх замын урд талын автобусны буудлаас Нисэхийн тойрог хүртэл №108-1 дугаартай нарс модны хооронд	494 у.м	25.0
Дүн /1-р бүлэг/	5107 у.м	273.3
<i>Хоёр. 22-ын товчооны зам дагууд мод сөөг тарих, арчлах ажил</i>		
2.1 Автозамын 2 талаар 10 км газарт улиас тарих /Мэргэжлийн компаниудад газрыг хуваарилан өгч гэрээ байгуулах/	5000 ш	85.0
2.2 Замын голын тусгаарлах зурваст хайлаас тарих	38000 ш	32.2
2.3 Нийт мод /улиас/, сөөг /хайлаас/-ийг усалж, арчлах ажил	43000 ш	43.0
Дүн /2-р бүлэг/	43000 ш	160.2
НИЙТ ДҮН /сая төгрөг/		433.5


Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2019 оны 05 сарын 02 өдрийн
 ...тушаалын... хавсралт



НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ХӨРСИЙГ АРИУТГАХ АЖИЛ ХИЙГДЭХ
 ГУДАМЖ, ЦЭЦЭРЛЭГ, ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГӨ

Багцын дугаар	Гудамж, цэцэрлэгийн нэрс	Ариутгал хийх талбайн хэмжээ /м2/	Зарцуулах зардал /сая.төгрөг/
1-р багц	Энхтайваны өргөн чөлөө /Эскадрилын хөшөөнөөс 5 шарын баруун урд уулзвар хүртэл/	55000	30.0
	Турк- Монголын найрамдал цэцэрлэг /УБИСургуулийн баруун талын/	10000	
	Хонхтой цэцэрлэг /Төв шуудангийн зүүн талын/	10000	
	Асашёрюүгийн цэцэрлэг, Жуулчны гудамж	2000	
	ДҮН	77000м2	30.0
2-р багц	Хувьсгалчдын цэцэрлэг /Засгийн газрын ордны арын/, Засгийн газрын ордны баруун, зүүн талын гудамж	10000	30.0
	Учралын цэцэрлэг /Төв музейн өмнөх/	2000	
	Чингэсийн өргөн чөлөө /Төв шуудангаас Яармагийн гүүр хүртэл/	14000	
	Сөүлийн гудамж /АН-ын байрнаас ТБД андуудын урд хүртэл/	13000	
	Бээжин, Эрхүүгийн гудамж	8000	
	Бага тойруу / УБИСургуулиас СУИС түүнээс Цэцэг төвийн уулзвар хүртэл/	17000	
	Циркын арын талбай	6000	
	Магсаржавын гудамж /Төмөр Замын Дээд Сургуулиас урагш Вокзал хүртэлх гудамж/	5000	
	ДҮН	75000м2	30.0
	НИЙТ ДҮН	152000 м2	60.0

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2019 оны 6 сарын 28-ны өдрийн
 А/1125 тушаалын 4 дүгээр хавсралт



НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ӨВЧИН, ХОРТОН ШАВЬЖТАЙ
 ТЭМЦЭХ АЖИЛ ХИЙГДЭХ ГУДАМЖ ЦЭЦЭРЛЭГ, ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГӨ

д/д	Гудамж, цэцэрлэгийн нэрс	Ариутгал хийх		Нийт мод, сөөгний тоо /ш/	Зарцуулах зардал /сая.төгрөг/
		Модны тоо /ш/	Бут сөөг /ш/		
1.	Сөүлийн гудамж	215	26000	26215	70.0
2.	Чингисийн өргөн чөлөө	195	25000	25195	
3.	Турк- Монголын цэцэрлэг	180	10400	10580	
4.	Хувьсгалчдын цэцэрлэг	120	25000	25120	
5.	Хонхтой цэцэрлэг	830	20000	20830	
6.	Учралын цэцэрлэг	60	3000	3060	
7.	Асашёрюүгийн цэцэрлэг	20	2500	2520	
8.	Холбооны өмнөх сквер	10	3000	3010	
9.	Энхтайваны өргөн чөлөө	2052	50000	52052	
10.	Магсаржавын гудамж	120	6050	6170	
11.	Самбуугийн гудамж	106	20000	20116	
12.	Их сургуулийн гудамж	58		58	
13.	Сүхбаатарын гудамж	110	1500	1610	
14.	Бага тойруу	600	18000	18600	
	ДҮН /ширхэг/			215136	70.0

Тайлбар: 2019 онд хотын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн өвчин, хортон шавьжтай тэмцэх ажлыг 2 үе шаттай явуулах бөгөөд энэ ажилд 6-р сард 70,0 сая, 8-р сард 70,0 сая төгрөгийг тус тус төсөвлөсөн.